



МОНГОЛБАНКНЫ МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХОРООНЫ ОРОН ТООНЫ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИХ ТУХАЙ ХҮСЭЛТ

Товч удирдамж: Нэр дэвших тухай хүсэлт гаргахдаа энэхүү загварт асуусан асуулт, шаардсан мэдээлэл бүрийн доор /ард/ хариултаа үнэн зөв бичнэ. Компьютерын програм ашиглаж бичсэн хүсэлтийг цаасаар хэвлэж гарын үсэг зурах бөгөөд уг эх хувь, түүний хавсралт мөн Word-ын файлыг цахим шуудангаар тус тус Байнгын хороонд явуулна.

Хуульд заасан шаардлага: Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 27³ дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан байна. Үүнд:

2.Орон тооны бус гишүүн дараахь шалгуурыг хангасан байна:

1/банк, санхүү, эдийн засгийн чиглэлийн их дээд сургууль, судалгаа, эрдэм шинжилгээний байгууллагад мэргэжлээрээ 10-аас дээш жил, үүний таваас доошгүй жилд макро эдийн засгийн бодлого, судалгаа шинжилгээний чиглэлээр ажилласан туршлагатай;

2/Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа банкны эрх бүхий албан тушаалтан, банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд, холбогдох этгээд биш;

3/ашиг сонирхлын зөрчилгүй.

НЭГ. НЭР ДЭВШИГЧИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА, НИЙТЛЭГ ШААРДЛАГА

1.1	Эцэг/эхийн нэр: Намсрай Ургийн овог: Арлынхан Нэр: Батнасан Хүйс: эрэгтэй Төрсөн он: 1970 Төрсөн газар: Увс аймаг Иргэний харьяалал: Монгол Одоо оршин суугаа аймаг /нийслэл, сум/ дүүрэг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 7-р хороо, <i>/мэдээлэл гаргагчийн зөвшөөрлөөр/</i>
1.2	Нэр дэвших тухай хүсэлт гаргаж буй албан тушаал МОНГОЛБАНКНЫ МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХОРООНЫ ОРОН ТООНЫ БУС ГИШҮҮН
1.3	Иргэний харьяалал Монгол Улсын иргэн мөн эсэх

	<i>/тийм, эсхүл үгүй гэж бичих. Үгүй бол Монгол Улсаас өөр улсын иргэний харьяалалтай байсан эсэхийг тодорхой бичих/</i> Монгол Улсын иргэн. Өөр ямар нэгэн орны харьяалалгүй
1.4	Боловсрол Дээд боловсрол эзэмшсэн сургууль тус бүрийг сүүлд төгссөн сургуулиас нь эхлэн он дарааллаар жагсааж, холбогдох нотлох баримтыг хавсаргана. <i>/сургууль тус бүрд суралцсан хугацаа, авсан зэрэг, огноог бичнэ/</i> 2007-2008 онуудад БНСУ Соганы их сургууль - докторын дараах сургалт 1996-2000 онуудад МУИС-ийн аспирантур 1998 онд МУИС-ийн магистрантур 1988-1993 онуудад МУИС-ийн Эдийн засгийн факультет
1.5	Боловсролын болон шинжлэх ухааны докторын зэрэг Эдийн засгийн ухааны доктор (Ph.D) Эдийн засгийн ухааны магистр (MA) Бакалавр -Гадаад худалдааны эдийн засаг
1.6	Эрүүл мэнд Сэтгэцийн өвчин, эмгэгтэй эсэхийг тодорхойлсон нотлох баримтыг жагсааж, хавсаргана. Сэтгэцийн өвчин эмгэгийн асуудлаар ямар нэгэн эмнэлэгт эмчлүүлж байсан удаагүй
1.7	Эрхэлсэн ажил Их, дээд сургууль төгссөнөөс хойш эрхэлсэн ажлыг тодорхойлон бичнэ. Эдийн засаг, банк, санхүүгийн чиглэлээр 12-оос дээш жил ажилласан туршлагатай, удирдлагын мэдлэг, мэргэшлийн ур чадвартай болохыг нотлох баримтыг хавсаргана. Ажилласан байгууллагыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар жагсаах бөгөөд ажил олгогч <i>/эсхүл, удирдах албан тушаалтан/-ийн нэр, хаяг, утасны дугаар, цахим шуудангийн хаяг, цахим хуудас болон ажлын байрны нэрийг бичнэ.</i> <ul style="list-style-type: none"> • 2023 оноос МУИС-ийн Бизнесийн сургуулийн захирал • 2013 – 2016 онуудад МУИС-ийн Бизнесийн сургуулийн захирал • 2016 - 2023 онуудад МУИС-ийн Бизнесийн сургуулийн профессор • 2012 – 2014 онуудад МУИС-ийн Эрдмийн зөвлөлийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга • 2007 – 2008 онуудад БНСУ-ын Соганг Их сургуульд зочин профессор • 2006 –2007, 2008 – 2010 онуудад МУИС-ийн ЭЗС-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга • 2004 –2007 онуудад МУИС ЭЗС Олон улсын худалдааны магистрын хамтарсан хөтөлбөрийн удирдагч • 2000 –2006 онуудад МУИС-ийн ЭЗС-ийн Маркетинг, олон улсын худалдааны тэнхимийн орлогч эрхлэгч • 2000 – 2013 онуудад МУИС ЭЗС-д багш, ахлах багш (2001), дэд профессор (2005), профессор (2010) • 1994 –1996 онуудад ҮХЯ-ны харьяа “Монгол худалдаа” концерн (УҮГ)-ын ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, 1996 – 1998 онд ТУЗ-ийн гишүүн, • 1993 –1998 онуудад ҮХЯ-ны харьяа Улсын бөөний худалдааны нэгдэл (1994 оноос “Бөөний худалдаа” ХК болж шинэчлэн зохион байгуулагдсан), “Монгол худалдаа” концерн (УҮГ)-т гадаад худалдааны

	<p>мэргэжилтэн, гадаад худалдааны менежер, концерны ерөнхий менежер, концерны Ерөнхий захирал,</p>
1.8	<p>Ашиг сонирхлын зөрчил</p> <p>Хуулийн этгээдийн хувьцаа эзэмшдэг, аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг эсэх, Банк бус санхүүгийн байгууллага, банкны хувьцаа эзэмшдэг эсэхийг бичих. /тийм, эсхүл үгүй гэж бичих. Тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, ямар хувьцаа, аж ахуйн үйл ажиллагааг ямар хугацаанд эзэмшиж, эрхэлж байгаа, эсхүл эзэмшиж, эрхэлж байсан талаараа хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/</p> <p>“Эрдэнэс Тавантолгой” компанийн 1072 хувьцаа эзэмшдэг. Өөр байгууллагад ямар нэгэн хувьцаа эзэмшдэггүй, аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэггүй.</p>
1.9	<p>Улс төрийн болон намын удирдах, гүйцэтгэх албан тушаал</p> <p>Сүүлийн таван жил улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах, гүйцэтгэх албан тушаал эрхэлж байсан эсэхийг бичих. /тийм, эсхүл үгүй гэж бичих. Тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, ямар албан тушаалыг ямар хугацаанд эрхэлж байгаа, эсхүл эрхэлж байсан талаар хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</p> <p>Үгүй</p>
1.10	<p>Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүнчлэлийн талаар</p> <p>Сүүлийн таван жил ямар мэргэжлийн холбоо, байгууллагад удирдах, гүйцэтгэх албан тушаал эрхэлж байсан, гишүүнчлэлийн талаар бичих. /тийм, эсхүл үгүй гэж бичих. Тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах, ямар албан тушаал, чиг үүрэг гүйцэтгэж байсан талаар хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/</p> <ul style="list-style-type: none"> • Торгоны замын орнуудын олон улсын логистикийн нийгэмлэгийн удирдах зөвлөлийн гишүүн (БНТУ-ын Станбул хотод төвтэй) • “Хөгжлийн төлөө эрдэмтэд” ТББ-ын УЗ-ийн гишүүн • 2019-2022 онуудад “Монгол Улсын Хөгжлийн банк”-ны ТУЗ-д хараат бус гишүүн, ТУЗ-ын цалин урамшууллын хорооны даргаар ажилласан • 2021 оноос Монгол улсын Ерөнхий сайдын дэргэдэх Эдийн засгийн бодлогын зөвлөлийн гишүүн • 2020 оноос ЗТХЯ-ны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн гишүүн • 2019 – 2022 “Монгол улсын Хөгжлийн банк”-ны ТУЗ-ийн хараат бус гишүүн, ТУЗ-ийн цалин, урамшууллын хорооны дарга • 2019 – 2020 онуудад Монгол улсын ЗГХЭГ-ын дэргэдэх урт хугацааны хөгжлийн бодлого боловсруулах нэгтгэл, аргазүйн ажлын хэсгийн гишүүн • 2018 – 2020 онуудад ЗГХЭГ-ын дарга, МУ-ын Сайдын орон тооны бус зөвлөх • 2017 оноос ОССК-ийн ТЗК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн

	<ul style="list-style-type: none"> • 2017 оноос Япон улсын Зүүн Хойд Азийн Эдийн засгийн судалгааны хүрээлэнгээс эрхлэн гаргадаг “North East Asian Economic Review” сэтгүүлийн редакцийн зөвлөлийн гишүүн • 2017 – 2020 онуудад Төв Азийн Эдийн засгийн хамтын ажиллагааны нийгэмлэг (CAREC)-ийн Зөвлөлдөх зөвлөлд Монгол улсыг төлөөлсөн гишүүн <p>2017 — 2020 онуудад БСШУС-ын дэргэдэх Дээд боловсролын бодлогын зөвлөлийн гишүүн</p>
1.11	<p>Мэргэжлийн ёс зүйн талаар Мэргэжлийн ёс зүйн зөрчил гаргаж байсан эсэх. <i>/тийм эсхүл үгүй гэж бичих. Тийм гэж хариулсан бол хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичих/.</i></p> <p>үгүй</p>
1.12	<p>Хэрэв доор дурдсан мэдээлэл нэр дэвшигчид байгаа бол</p> <p>-Өөрийн боловсруулсан, хянасан судалгааны ажил, ном, өгүүлэл, тайлан, шийдвэр, зөвлөмж зэрэг аливаа хэлбэрээр хэвлүүлсэн материал байгаа бол гарчиг, хэвлэсэн газар, огноог бичнэ.</p> <p>-Өөрийн харьяалагддаг байгууллагын нэрийн өмнөөс бэлдсэн, эсхүл бэлдэхэд оролцсон аливаа хууль тогтоомж, дүрэм, журам, шийдвэр, тайлан, зөвлөмж болон бусад материал байгаа бол түүнийг хэвлэсэн байгууллагын нэр, хаяг, огноо, гол агуулгыг бичнэ.</p> <p>-Сүүлийн таван жилийн хугацаанд хэлэлцүүлсэн лекц, илтгэл, нээлтийн үг зэрэг илтгэл, ярианы товч утга, огноо, газар, танилцах арга замыг бичнэ. Тухайн илтгэл, ярианы хуулбарыг хийх боломжгүй бол түүнийг зохион байгуулсан байгууллагын нэр, хаяг, илтгэл, ярианы огноо, товч утгыг бичнэ.</p> <p>-Сүүлийн таван жилийн хугацаанд хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд өгсөн ярилцлага, нийтлэлийг хамгийн сүүлийнхээс нь эхлэн жагсааж бичнэ. Ярилцлага, нийтлэлүүдийн огноог зааж, боломжтой бол ярилцлагын тэмдэглэл, дүрс бичлэг, нийтлэлийг хуулбарлан өгнө.</p> <p><i>/Жич: Дээр дурдсан материал тус бүрээс нэгийг хавсаргах бөгөөд боломжтой бол цахимаар үзэх линкийг тусгана/</i></p> <p>Гадаад, дотоодын болон олон улсын байгууллагуудын 35 судалгааны төсөлт ажилд оролцсоноос 15-ыг удирдсан. Нэг сэдэвт бүтээл 4, нэгэн сэдэвт хамтын бүтээл 5, сурах бичиг 4, ном гарын авлага 6-г тус тус бичиж хэвлүүлсэн ба 3 номыг редакторлосон. Нийт 36 өгүүлэл хэвлүүлснээс 16-г олон улсад, үүнээс 5-ыг дэлхийн өндөр түвшний Q1, Q3, Q4 эрэмбийн сэтгүүлүүдэд хэвлүүлсэн. Олон улсын хуралд 35 удаа оролцож илтгэл тавьсан бөгөөд олон нийтийн хэвлэл мэдээлэлд тогтмол ярилцлага өгч ирсэн.</p> <p>Миний хэвлүүлсэн бүтээлүүд, тэдгээрийн олон улсын хэмжээний ишлэлийн талаарх мэдээллийг https://scholar.google.com/citations?user=hK5Uq4gAAAAJ&hl=en&oi=ao линкээр орж үзэх боломжтой.</p>


ХОЁР. ХИЙХ АЖИЛ, НЭР ДЭВШСЭН ҮНДЭСЛЭЛЭЭ БИЧСЭН ТАЙЛБАР

2.1	<p>Тухайн албан тушаалд томилогдвол хийх ажил, уг албан тушаалд нэр дэвшсэн үндэслэлээ тайлбарлаж тодорхой, ойлгомжтой бичнэ. <i>/500-1000 үгэнд багтаана/.</i></p> <p>Сүүлийн жилүүдийн нөхцөл байдлаас үзэхэд Төв банкнаас явуулж буй мөнгөний хатуу бодлого, ЗГ-ын төсвийн хэт тэлэлт хоёр нь мөнгөний болон сангийн бодлогын хооронд уялдаа холбоо сул байгааг харуулж байгаа юм. Энэ нь цаашдаа инфляци, зардлын өсөлт, зээлийн хүү зэргээр дамжин өрсөлдөх чадварыг бууруулах, макро эдийн засгийн нөхцөл байдлыг тогтворгүйжүүлэх эрсдэлтэй байна.</p> <p>Хөгжлийн банк болон Төрийн банк зэрэг төрийн өмчийн оролцоотой банкууд дотоодын аж ахуйн нэгжүүдэд ДХБ-ын дүрэм журмаар хориглосон татаас, дэмжлэг үзүүлж байгаа нь цаашид энэ байгууллагын гишүүн орнуудаас манай улсын эсрэг хариу арга хэмжээ авах нөхцөл байдалд оруулах эрсдэлтэй байгаа тул хууль тогтоомжид шаардлагатай өөрчлөлтүүдийг оруулахын төлөө ажиллана.</p> <p>Дижиталчлал, хиймэл оюун зэрэг нь дэлхий нийтийн хэмжээнд банкны салбарын зардал болон эрсдлийг бууруулах гол арга хэрэгсэл болох шинжтэй байна. Үүнтэй холбоотойгоор банкны салбарт дижитал шийдлүүдийг нэвтрүүлэх, хиймэл оюунд суурилсан эрсдлийн удирдлагыг нэвтрүүлэх, шаардлагатай дүрэм журам, зохиуулалтыг бий болгох шаардлагатай байгаа юм.</p> <p>Бодлогын хүү нь арилжааны банкнуудын хадгаламж, зээлийн хүү, тэдгээрээр дамжин банкны салбар дах мөнгөний нийлүүлэлтэд хүчтэй нөлөөлдөг. Иймд бодлогын хүүг шинжлэх ухааны арга аргачлалд тулгуурлан оновчтой тогтоох асуудал чухал. Нөгөө талаас мөнгөний нийлүүлэлт, түүний дотор эмиссийг оновчтой хэмжээний талаарх тооцоололд суурилан хэрэгжүүлэх нь чухал байгаа юм.</p> <p>Иймд цаашид Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны орон тооны бус гишүүнээр сонгогдсон нөхцөлд:</p> <ul style="list-style-type: none">• Мөнгөний бодлого, сангийн бодлогын уялдааг сайжруулах• Банкны салбарын хууль тогтоомж, дүрэм журмуудыг олон улсын гэрээ хэлэлцээрүүдэд нийцүүлэх• Банкны салбарын зардал ба эрсдлийг бууруулах тал дээр ажиллах• Бодлогын хүү болон мөнгөний нийлүүлэлтийн хэмжээг оновчтой тогтоох гэсэн асуудлуудад төвлөрч ажиллах болно.
------------	--

Хүсэлт гаргагч:

Эцэг/эхийн нэр: Намсрай

Өөрийн нэр: Батнасан

Гарын үсэг: 

Он, сар, өдөр: 2024-12-19